ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 5-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: ӨВА-2022/78/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он


Тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com

Аудитор: П.Сосорбурам

Утас: 94422277 Цахим хаяг:psosor@yahoo.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ... 3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ... 3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ... 3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ... 6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ... 6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 9
3. Аудитын тайлан ... 11
3.1 Ерөнхий зүйл ... 11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ... 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ... 13
3.4 Материаллаг байдал ... 13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ... 13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ... 13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ... 14
3.8 Аудитын гол асуудал ... 14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ... 14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ... 14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ... 15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ... 15
4. Аудитын илрүүлэлт ... 15
4.1 Залруулсан алдаа ... 15
4.2 Төлбөрийн акт ... 15
4.3 Албан шаардлага ... 16
4.4 Зөвлөмж ... 16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ... 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг.
Утас/Факс: (976) 7032 3253.
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2022.02.14 № 152
танай __________-ны №__________-т

АРВАЙХЭЭРСУМЫН ЕБ-ЫН
5-Р СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Г.ЗУУННАСТ ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 -д заасны дагуу Арвайхээр сумын ЕБ-ын 5-р сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арвайхээр сумын ЕБ-ын 5-р сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

D:\Auditiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **130,132,889.00** | **144,079,955.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **104,000.00** | - |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **102,000.00** | - |
| **3121** | **Төгрөг** | **102,000.00** | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 102,000.00 | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **130,030,889.00** | **144,079,955.00** |
| **351** | **Түүхий эд материал** | **60,133,150.00** | **82,326,269.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 59,991,800.00 | 82,197,119.00 |
| 35130 | Эм боох материал | 141,350.00 | 129,150.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **69,897,739.00** | **61,753,686.00** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 944,990.00 | 1,057,407.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 772,300.00 | 124,200.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,347,000.00 | 2,120,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 11,123,660.00 | 646,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 55,709,789.00 | 57,805,579.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **460,705,245.67** | **4,401,033,473.83** |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | - | - |
| **371** | **Урт хугацаат хадгаламж** | - | - |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **460,705,245.67** | **4,401,033,473.83** |
| 391 | Газар | | 540,000,000.00 |
| **392** | **Биет хөрөнгө** | **454,950,245.51** | **3,857,174,473.55** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | - | 3,510,000,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | | (58,500,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 240,982,074.40 | 260,892,119.28 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (49,983,153.04) | (98,229,067.72) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 259,754,786.40 | 268,102,486.40 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (44,719,184.21) | (77,594,082.53) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 900,000.00 | 900,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 38,651,200.00 | 41,028,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (4,557,808.04) | (9,982,782.80) |
| 39217 | Ном | 13,922,330.00 | 20,557,800.92 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **5,755,000.16** | **3,859,000.28** |
| 39301 | Програм хангамж | 7,805,000.00 | 7,805,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,049,999.84) | (3,945,999.72) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **590,838,134.67** | **4,545,113,428.83** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **590,838,134.67** | **4,544,793,428.83** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **590,838,134.67** | **4,544,793,428.83** |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | - | 540,000,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **590,838,134.67** | **4,004,793,428.83** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 590,838,134.67 | 590,838,134.67 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 3,414,275,294.16 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **590,838,134.67** | **4,545,113,428.83** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,969,507,581.00** | **5,092,445,685.80** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **-** | **-** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **37,924,041.00** | **3,555,093,534.80** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 37,924,041.00 | 3,555,093,534.80 |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | | |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 19,267,041.00 | 3,532,092,815.80 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 18,657,000.00 | 22,518,719.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,931,583,540.00** | **1,537,352,151.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,735,621,840.00 | 1,328,501,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,735,621,840.00 | 1,328,501,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 9,925,000.00 | 12,482,851.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 200,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 1,109,156.00 |
| 131104 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 9,750,000.00 | 11,173,695.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 175,000.00 | 482,000 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 186,036,700.00 | 196,367,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 186,036,700.00 | 196,367,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,910,464,878.92** | **1,678,170,391.64** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,910,464,878.92** | **1,678,170,391.64** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,778,625,608.92 | 1,676,470,284.64 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,088,250,729.00 | 1,118,833,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 792,770,701.00 | 839,915,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 204,302,286.00 | 212,735,700.00 |
| 210104 | Урамшуулал | 91,177,742.00 | 66,182,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 138,435,441.00 | 148,174,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 94,835,245.85 | 108,492,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,082,565.01 | 9,920,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,855,978.00 | 7,936,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,151,043.04 | 1,984,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,510,609.10 | 19,841,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 151,368,700.00 | 171,849,293.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,887,101.00 | 9,771,953.00 |
| 210302 | Түлш, халаалт | 140,550,369.00 | 153,300,840.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,931,230.00 | 8,776,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 6,768,027.00 | 10,059,838.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,314,285.00 | 4,253,528.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 938,700.00 | 967,900.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 80,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 734,600.00 | 734,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,700,442.00 | 4,103,810.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| 210408 | Бараа материал акталсны зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 31,404,724.00 | 47,359,660.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,790,559.00 | 466,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 29,614,165.00 | 46,892,760.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 24,975,300.00 | 23,223,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 24,975,300.00 | 23,223,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 328,000.00 | 240,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 328,000.00 | 240,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,289,500.00 | 6,201,356.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,483,100.00 | 6,201,356.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 806,400.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 333,805,187.92 | 150,529,037.64 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 253,322,100.00 | 855,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,992,700.00 | 2,731,550.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 78,490,387.92 | 146,941,787.64 |
| 210904 | Найдваргүй авлагын андагдал | | |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 131,839,270.00 | 1,700,107.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 45,260,000.00 | 1,700,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 45,260,000.00 | 1,700,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 86,579,270.00 | 107.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 86,579,270.00 | 107.00 |
| 213501 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **59,042,702.08** | **3,414,275,294.16** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН** | | - |

| | | | |
|---|---|---|---|
| | **ДҮН** | 5,279,416.58 | |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 5,279,416.58 | |
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (5,279,416.58) | - |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **53,763,285.50** | **3,414,275,294.16** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | **590,838,134.67** | 590,838,134.67 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | **590,838,134.67** | **590,838,134.67** |
| C08 | **2020оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | **590,838,134.67** | **590,838,134.67** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | **590,838,134.67** | **590,838,134.67** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | **590,838,134.67** | **590,838,134.67** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 540,000,000.00 | | 540,000,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | 3,414,275,294.16 | 3,414,275,294.16 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **540,000,000.00** | **4,005,113,428.83** | **4,545,113,428.83** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,931,583,540.00** | **1,537,834,151.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | - | **482,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 482,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 482,000.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,735,621,840.00 | 1,328,501,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,735,621,840.00 | 1,328,501,900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 9,925,000.00 | 12,482,851.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 200,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | | 1,109,156.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | хөрөнгө | | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | 9,750,000.00 | 11,173,695.00 |
| **1311** | **Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл** | 175,000.00 | |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 175,000.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 186,036,700.00 | 196,367,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага | 186,036,700.00 | 196,367,400.00 |
| 133004 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | 3,880,000.00 | 640,015.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,874,581,240.00** | **1,527,883,951.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,874,581,240.00** | **1,527,883,951.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,707,095,870.00** | **1,484,643,244.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,088,250,729.00 | 1,118,833,600.00 |
| 210101 | Үндсэн цалин | 792,770,701.00 | 839,915,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 204,302,286.00 | 212,735,700.00 |
| 210104 | Урамшуулал | 91,177,742.00 | 66,182,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 138,435,441.00 | 148,174,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 94,835,245.85 | 108,492,500.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,082,565.01 | 9,920,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,855,978.00 | 7,936,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,151,043.04 | 1,984,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 21,510,609.10 | 19,841,000.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 151,368,700.00 | 171,849,293.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,887,101.00 | 9,771,953.00 |
| 210302 | Түлш, халаалт | 140,550,369.00 | 153,300,840.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,931,230.00 | 8,776,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 22,307,000.00 | 7,202,795.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,129,200.00 | 1,937,995.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 938,700.00 | 967,900.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 140,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 734,600.00 | 757,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 19,364,500.00 | 3,539,400.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,497,100.00 | 1,234,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,748,900.00 | 462,900.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 748,200.00 | 771,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 29,966,000.00 | 24,518,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 29,966,000.00 | 24,518,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 328,000.00 | 240,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 328,000.00 | 240,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,289,500.00 | 7,526,356.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,483,100.00 | 7,526,356.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 806,400.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 270,653,400.00 | 5,064,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 259,722,100.00 | 855,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,931,300.00 | 4,208,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **167,485,370.00** | **38,115,707.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 80,906,100.00 | 38,115,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 35,646,100.00 | 36,415,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 45,260,000.00 | 1,700,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 86,579,270.00 | 107.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 86,579,270.00 | 107.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **57,002,300.00** | **15,075,200.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | - | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **56,900,300.00** | **15,177,200.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **56,900,300.00** | **15,177,200.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 56,900,300.00 | 15,177,200.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 56,900,300.00 | 15,177,200.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(56,900,300.00)** | **(15,177,200.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 102,000.00 | (102,000.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | 102,000.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 102,000.00 | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,948,464,300.0 | 1,835,079,270.0 | 1,524,869,300.0 | 1,524,869,300.0 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,948,464,300.0 | 1,835,079,270.0 | 1,524,869,300.0 | 1,524,869,300.0 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,865,151,200.0 | 1,754,173,170.0 | 1,486,953,700.0 | 1,486,953,700.0 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,179,206,900.0 | 1,088,250,729.0 | 1,118,833,500.0 | 1,118,833,600.0 |
| 210101 | Үндсэн цалин | 829,563,800.0 | 792,770,701.0 | 838,090,800.0 | 839,915,800.0 |
| 210102 | Нэмэгдэл | 257,001,300.0 | 204,302,286.0 | 214,560,700.0 | 212,735,700.0 |
| 210104 | Урамшуулал | 92,641,800.0 | 91,177,742.0 | 66,182,000.0 | 66,182,100.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 152,074,500.0 | 138,435,441.0 | 148,174,500.0 | 148,174,500.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 98,767,600.0 | 94,835,245.9 | 108,492,500.0 | 108,492,500.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,326,700.0 | 11,082,565.0 | 9,920,500.0 | 9,920,500.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,661,400.0 | 8,855,978.0 | 7,936,400.0 | 7,936,400.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,665,300.0 | 2,151,043.0 | 1,984,100.0 | 1,984,100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,653,500.0 | 21,510,609.1 | 19,841,000.0 | 19,841,000.0 |
| **2103** | **Байр шиглалттай холбоотой тогтмол зардал** | 151,368,700.0 | 151,368,700.0 | 171,849,400.0 | 171,849,293.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,965,000.0 | 5,887,101.0 | 11,995,300.0 | 9,771,953.0 |
| 210302 | Түлш, халаалт | 136,177,500.0 | 140,550,369.0 | 151,077,600.0 | 153,300,840.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,226,200.0 | 4,931,230.0 | 8,776,500.0 | 8,776,500.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,092,300.0 | 28,092,300.0 | 6,657,000.0 | **6,656,900.0** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,129,200.0 | 1,129,200.0 | 1,364,300.0 | 1,364,300.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 938,700.0 | 938,700.0 | 967,900.0 | 967,900.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 4,020,300.0 | 4,020,300.0 | 1,052,200.0 | 1,052,200.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 734,600.0 | 734,600.0 | 757,500.0 | 757,500.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 21,269,500.0 | 21,269,500.0 | 2,515,100.0 | 2,515,000.0 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,497,100.0 | 2,497,100.0 | 1,234,500.0 | **1,234,500.0** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,748,900.0 | 1,748,900.0 | 462,900.0 | 462,900.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 748,200.0 | 748,200.0 | 771,600.0 | 771,600.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 61,868,000.0 | 56,368,000.0 | **33,518,000.0** | **33,518,000.0** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 18,200,000.0 | 12,700,000.0 | | |
| 210602 | Тавилга | 9,000,000.0 | 9,000,000.0 | 9,000,000.0 | 9,000,000.0 |
| 210604 | Урсгал засвар | 34,668,000.0 | 34,668,000.0 | 24,518,000.0 | 24,518,000.0 |
| 26 | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | | | | **107.0** |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | | | 107.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,210,800.0 | 328,000.0 | 240,000.0 | 240,000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,210,800.0 | 328,000.0 | 240,000.0 | 240,000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,289,500.0 | 3,289,500.0 | 1,382,600.0 | 1,382,600.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,483,100.0 | 2,483,100.0 | 1,382,600.0 | 1,382,600.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 806,400.0 | 806,400.0 | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 285,543,400.0 | 285,543,400.0 | 5,064,200.0 | 5,064,200.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 274,362,100.0 | 274,362,100.0 | 855,700.0 | 855,700.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,181,300.0 | 11,181,300.0 | 4,208,500.0 | 4,208,500.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | | 37,915,600.0 | 37,915,600.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 83,313,100.0 | 80,906,100.0 | 37,915,600.0 | 37,915,600.0 |
| **213205** | Төрөөс иргэдэд олгохтэтгэмж,урамшуулал | 36,843,100.0 | 35,646,100.0 | 36,415,600.0 | 36,415,600.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 46,470,000.0 | 45,260,000.0 | 1,500,000.0 | 1,500,000.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,948,464,300.0 | 1,835,079,270.0 | 1,524,869,300.0 | 1,524,869,300.0 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,762,427,600.0 | 1,649,042,570.0 | 1,328,501,900.0 | 1,328,501,900.0 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,762,427,600.0 | 1,649,042,570.0 | 1,328,501,900.0 | 1,328,501,900.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 186,036,700.0 | 186,036,700.0 | 196,367,400.0 | 196,367,400.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 186,036,700.0 | 186,036,700.0 | 196,367,400.0 | 196,367,400.0 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 97 | 97 | 89 | 89 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 1 | 1 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 67 | 67 | 65 | 65 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 29 | 29 | 23 | 23 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **12,964,851.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **12,964,851.00** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **12,764,851.00** |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **1,496,095.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 573,695.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 922,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 11,268,756.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 11,268,756.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 200,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,309,156.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **12,964,851.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 200,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,109,156.00 |
| 140020 | Дансны орлого | 10,890,000.00 |
| 30015 | Нэр данс зөрүү төсөл хөтөлбөрийн орлого | 765,695.00 |
| IV | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Арвайхээр сумын 5-р сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Чадварлаг аудит ХХК-ийн аудитор П.Сосорбурам гүйцэтгэж, хяналтыг Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг, аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 01-р сарын 21-ны өдрийн 07 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

**3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Тус байгууллагын зорилго: Сурагчдыг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

Зорилт-1. Суралцах суурь чадварыг сайжруулах

- Алдаагүй зөв бичиж сурах аян өрнүүлэх
- Сар бүр Номын клубийн үйл ажиллагааг зохион байгуулж хэвших
- Сурагчдын унших, бичих, тооцоолох чадварыг дээшлүүлэх
- Хичээлийн судалгааг сар бүр зохион байгуулах

Зорилт-2. Хувийн зохион байгуулалтыг дээшлүүлж, сургуулийн дүрэм журам дэгээ баримтлах

- “1 өдөр 1 мэдээлэл” үйл ажиллагааг тогтмолжуулах
- Үдийн цайнд орохдоо гараа ариутгаж хэвших
- Биеийн тамирын хувцас болон дүрэмт хувцсаа бүрэн өмсөж хэвших
- Хичээлийн цаг ашиглалтыг сайжруулах
- Баруун гарын дүрмээ баримтлах аян өрнүүлэх
- Их завсарлагаагаар гимнастик хийж хэвших

Зорилт-3. Хүүхдийг хамгаалах, хөгжүүлж төлөвшүүлэхэд сургууль, багш, эцэг эхийн хамтын ажиллагаанд ахиц гаргах

- Хүүхэд хамгааллын бодлогоо хэрэгжүүлж дүгнэх
- Гурвалсан гэрээ хийж дүгнэх, хэлэлцүүлэг зохион байгуулах
- Монгол өв уламжлал, ёс заншлын талаар өдөрлөг зохион байгуулах
- Сайн үйлсийн аян зохион байгуулах
- ХӨУБ-ын үйл ажиллагаагаар дамжуулан хүүхэд төлөвшүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус сургуулийн бүтцэд дотоод хяналтын орон тооны алба байхгүй. Дотоод хяналтын нэгжийг 2021 оны 3-р сарын 10 –ны өдрийн А/10 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй томилон байгууллагын дотоод хяналтын журмыг мөрдөн ажилладаг.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 5-р сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 1678.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 16.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Тус байгууллагын хувьд тайлант онд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 4.4 сая төгрөгийн эд хогшил, 1.1 сая төгрөгийн ном, 2.4 сая төгрөгийн бусад үндсэн хөрөнгө 2020 онд хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтад оруулсан 3510.0 сая төгрөгийн барилга тус тус нэмэгдсэн. Бараа материалын хувьд өмнөх оноос 14 сая төгрөгөөр нэмэгдсэн нь хандив тусламжаар сургалтын хэрэглүүд хүлээн авсан байна.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус газар нь өөрийн орлого байхгүй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан 1524.8 сая төгрөгийг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлжээ. Санхүүжилт өмнөх оноос 16.9 хувиар буурсан байна. Энэ нь цар тахалтай холбоотой хангамжийн материалын зардал буурсантай холбоотой юм.

**3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1524.9 сая төгрөгөөр санхүүжигдэн, 1524.9 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага тайлант онд 12.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг авч, нийтлэг ажил үйлчилгээний зардалд 11.2 сая төгрөг,бичиг хэргийн зардалд 0.6 сая төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлд 0.9 сая төгрөг нэг удаагийн тэтгэмж, урамшуулалд 0.9 сая төгрөг тус тус зарцуулсан байна .

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Тайлант онд 0.6 сая төгрөгөөр буйдан сандал, 1.4 сая төгрөгөөр буйдан, 1.8 сая төгрөгөөр хивс 0.4 сая төгрөгөөр ажилчдын нормын хувцас худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүйгээс үүдэлтэй гарсан зөрчил юм. Мөн цэвэр бохир ус, дулаан, цахилгаан эрчим хүчний зардлуудын Э-баримт байхгүй байгаа нь аудитын хувьд гол онцлох асуудал байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй,

Шилэн дансны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сар бүр , тухай бүр, улирал бүр , бүтэн жилээр мэдээг цаг хугацаанд нь тогтмол мэдээллээ шилэн дансанд байршуулдаг.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Өвөрхангай аймгийн 5-р сургууль нь 2021 онд 150 мэдээлэл шилэн дансанд байршуулахаас 141 мэдээллийг хугацаандаа байршуулсан, 1 мэдээлэл байршуулах хугацаа болоогүй, 8 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Нийт мэдээллийн 95 хувийг хугацаандаа 5 хувийг хугацаа хоцроож оруулсан.

Өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах аливаа шийдвэрийг тухай бүр байршуулахаас мэдээллүүдийг байршуулаагүй байна.

Тус илэрсэн зөрчил нь Шилэн дансны хууль, Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 26 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтуудыг зөрчсөн байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар доорх зөрчил илэрсэн байна

1 Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулаагүй

2 Хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон барилгыг үндсэн хөрөнгөд бүртгээгүй байсан

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөрөнгө , мөнгө зарцуулах шийдвэрийг хууль дүрмийн хэмжээнд бэлтгэж зарцуулах

## 4. Аудитын илрүүлэлт

Тайлант онд тавилга эд хогшил 3.8, ажилчдын нормын хувцас 0.4, бүгд 4.2 сая төгрөгийн худалдан авсан нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчсөн байна. Аудитаар нийт 4.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1 зөрчилд 1 албан шаардлага өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Байхгүй болно.

### 4.2 Төлбөрийн акт

Байхгүй болно.

### 4.3 Албан шаардлага

Дээрх зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

1.1. <u>Илрүүлэлт:</u>

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, аливаа төрлийн худалдан авалт, үйлчилгээний зардалд И-баримтыг үндэслэл болгоогүй байна.

<u>Өгсөн зөвлөмж</u>:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, аливаа төрлийн худалдан авалт, үйлчилгээний зардалд И-баримтыг үндэслэн зардлаар хүлээн зөвшөөрөх.

2. Шилэн дансны тухай хуульд заасан заалтуудыг бүрэн хэрэгжүүлж, хуулийн хугацаанд мэдээллийг байршуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Арвайхээр сумын 5-р сургууль | 3 | 4.2 | 0 | 0 | 0 | 0 | 2 | 4.2 | 1 | 0 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР П.СОСОРБУРАМ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР